



Г.Лхаахүү, МУБИС-ийн хүндэт доктор,
БС-ийн ахмад багш

КИРИЛ ҮСГИЙН ХИЧЭЭНГҮЙ БИЧГИЙН СУРГАЛТЫН ТҮҮХЭН ТОЙМООС ҮҮДСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ

Abstract: From the moment of its origination human history demanded script in order to develop relationship between them. There are three types of scripts : in the form of drawing, sound and form which humans have been using. The sound script is mostly used than the other two. Graphic is asystem which studies phoneme and which consists of letters. Graphic is used to study kind of scripts, procedures to be followed in writing and historic developments of writings. The first script in human history was Phoenic script, and in the west from Phoenix Armeiy, in the east Greece scripts were originated respectively. The scientists consider that the Armeiy script which was originated from Phoenix was used by Sogd (Iranian ancestry), then by Uigar and Mongols. In their research the scientists presumed Summary:

From the moment of its origination human history demanded script in order to develop relationship between them. There are three types of scripts : in the form of drawing, sound and form which humans have been using. The sound script is mostly used than the other two. Graphic is asystem which studies phoneme and which consists of letters. Graphic is used to study kind of scripts, procedures to be followed in writing and historic developments of writings. The first script in human history was Phoenic script, and in the west from Phoenix Armeiy, in the east Greece scripts were originated respectively. The scientists consider that the Armeiy script which was originated from Phoenix was used by Sogd (Iranian ancestry), then by Uigar and Mongols. In their research the scientists presumed that the script was used around VIII century. Graphic is divided into 2 research groups which are graphic adoption and relationship between tone and letter. The letters are used to note human communication, and it has been developing as the time goes on. For thousand years the letters have been changing and developing and it has been the most important development in

linguistic science. The letters can be seen, touched and written. As the time goes on we realize and appreciate how letters and its tones influenced in our lives. Furthermore with the help of letters we can review the past researches in all level of society and make a note about current researches in order to use it in the future. The way of using graphics will have different attitudes and structures. That's why there will be a question about how it should be taught to our children. So the goal must be set to study special features of letters, their historic evolution, in order to teach modern teachers. As teachers we should study and possess the technology of writing, as this is one of the most important requirements so far.

That the script was used around VIII century. Graphic is divided into 2 research groups which are graphic adoption and relationship between tone and letter. The letters are used to note human communication, and it has been developing as the time goes on. For thousand years the letters have been changing and developing and it has been the most important development in linguistic science. The letters can be seen, touched and written. As the time goes on we realize and appreciate how letters and its tones influenced in our lives. Furthermore with the help of letters we can review the past researches in all level of society and make a note about current researches in order to use it in the future. The way of using graphics will have different attitudes and structures. That's why there will be a question about how it should be taught to our children. So the goal must be set to study special features of letters, their historic evolution, in order to teach modern teachers. As teachers we should study and possess the technology of writing, as this is one of the most important requirements so far.

Түлхүүр үг: Үсэгзүй, заах арга, хэл шинжлэл, технологи, зураг, дүрс, авиа, бичгийн хэл, кирил

бичиг, хичээнгүй бичих арга зүй.

Удиртгал

Хүн үүссэн цагаасаа өөр хоорондоо хийгээд цаашилбал овог, аймаг бүлгээрээ харилцан ойлголцох, санаа бодлоо илэрхийлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарч, энэ үүднээс харилцаагаа зураг, дүрс, дохио зангаагаар гүйцэлдүүлж байв. Ийнхүү үсэг бичиг үүсэх нөхцөл бүрэлдэж, хүн төрөлхтөн зургийн, дүрсийн, авианы гэсэн гурван хэлбэрийн бичгээр харилцаж ирсэн түүхтэй. Эдгээрээс авианы бичгийг голлон хэрэглэсээр байна.

“Хэл яриаг тэмдэглэхэд хэрэглэдэг зураасан тэмдгийн тогтолцоог бичиг гэнэ. Бичиг бол 3000 жилийн тэртээ үүссэн хүн төрөлхтөний зохиосон, оюуны асар том бүтээл юм”⁶

Хүн төрөлхтөний бичиг үсгийн анхных нь финик бичиг бөгөөд финикээс дорно дахинд армей, өрнө дахинд (герег) грек бичиг салбарлан үүссэн түүхтэй. Финикээс гаралтай армей бичгийг Иран угсааны Согд нар, Согдоос Уйгарууд авч, Монголчууд үүнийг дам авсан гэж үсэг бичиг судлаач эрдэмтэд үздэг. Уйгар улсын хүчирхэг мандаж байсан VIII зууны үед авсан болов уу гэж эрдэмтэд судалгааны бүтээлүүддээ дурдсан байдаг.

XVI зууны хоёрдугаар хагаст монголчууд нэгэн зүйлийн үсэг зохион хэрэглэж байсан нь улсын үсэг буюу “Монгол улсын үсэг”. Олонд алдаршсан нэр нь Дөрвөлжин үсэг. Дөрвөлжин гэдэг нь үсгийнхээ хэлбэрээр нэрлэсэн нэр ажээ. Монголчууд үсэг бичгээ өөрчлөн сайжруулсаар ирсэн эрмэлзлийн нэг үр дүн нь 1648 онд Ойрадын зая бандида Намхайжамц “Уйгаржин монгол бичиг”-т цэг тэмдэг нэмж, “Тодорхой үсэг буюу Тод үсэг” зохиов. “Тод үсэг” гэж нэрлэсэн гол учир нь бичих арга тэмдэглэгээндээ анхаарлаа хандуулан, сайжруулсантай холбоотой байна.

Өндөр гэгээн Занабазар 1686 онд Соёмбо үсэг зохиожээ. Соёмбо гэдэг нь эртний Энэтхэгийн судрын хэлээр “Өөрөө болсон гэгээн үсэг” гэсэн үг ажээ. Өнөөгийн бидний хэрэглэж байгаа Кирил үсэг нь финикээс үүсэж, Грекээр дамжин Болгарг нэвтэрч, 9-р зуунд ах дүү Кирил Мифодай энэхүү үсгийг зохион хэрэглэсэн билээ. Зохиосон хүнийхээ нэрээр дэлгэрсэн эл үсгийг 10 - р зуунд Оросод, 20 - р зууны эхэн үеэс (1941 он) Монгол улс авч хэрэглэн түүндээ тулгуурласан шинэ үсгийн дүрэм зохион, ард нийтгээрээ суралцаар, 1946 оноос албан хэргийг

⁶ Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг. (2014), 34 дэх тал

хөтлөн явуулах бичиг болгосноор өнөөг хүртэл хэрэглэж байна.

Үндсэн хэсэг

Үсэгзүй, хэл шинжлэлийн салбар ухаан болох нь:

Үсэгзүйг, үсэгзүйн хэрэглүүр, авиа үсэг хоёрын харьцаа гэсэн хоёр хэсэгт авч судалдаг. Үсэг нь хүний харилцааг тэмдэглэх хэрэглүүр болдгийн хувьд хөгжиж ирсэн цаг хугацаатай, хувьсан өөрчлөгдсөн үетэй, үргэлж боловсрон сайжирч байдаг хэл шинжлэлийн, хөгжлийн түүхэн явцын нэгэн үзэгдэл, дохио тэмдэг гэж хэлж болно. Үсгийг бүрдүүлж байгаа зурааснууд (үсэг) нь хэлний авиалбарын тогтолцоонд хэрхэн харьцаж байгааг судлах хэл шинжлэлийн салбар ухааныг үсэгзүй (график) гэнэ. Мөн “хэлний тэмдгийн бүх цогцыг ч үсэг зүй”⁷ гэж нэрлэдэг. Бичигт тэмдэглэж байгаа бүх зураас (цэг таслал, цуваа цэг, цэгтэй таслал, хаалт, хашилт, асуулт, анхаарлын тэмдэг, цагаан толгойн үсгүүд) бүгд үсэг зүйн хэрэглүүр болно. Ийнхүү үсэгзүйн хэрэглүүр нь үсгийг бүтээх хэрэглүүр болоод зогсохгүй, үгээ зөв бичих, хүний сэтгэлийн хөдлөлөө илэрхийлэхэд ч чухал нөлөө үзүүлдэг.

Олон мянганы туршид өөрчлөгдөн ирсэн үсэг бичиг нь хүний нийгмийн хэлний хөгжил, харилцааг өртөөлөн ирсэн хэл шинжлэлийн ухааны чухал хэрэглүүр юм. Хэлний харилцаа түүний, авиаг тэмдэглэдэг үсэг бичгийн ачаар нийгмийн бүх л салбарын өмнөхийг судалж, өнөөдрөө бүтээн тэмдэглэж, ирээдүйдээ үлдээдэг.

Хичээнгүй бичигт сургаж ирсэн уламжлал (кирил үсгийн жишээн дээр)

Үсгээ, хэрхэн бичих, яаж гоё бичүүлэх, ямар шугамтай дэвтэр хэрэглэх, хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан, ямар аргагүй сонгох зэрэг сурах, сургахзүйн өргөн хүрээний асуудлуудыг шийдвэрлэж иржээ. Манай ахмад заах аргачид, хэл шинжээчид олон арга, санаа сүвэгчлэн хайж боловсруулсаар, өөрийн орны нийгмийн хөгжил, суралцагчдынхаа байдалд нийцүүлэн үлэмж ажлуудыг хийсээр ирсэн билээ. Кирил үсэг нь нэгэнтээ Оросоор дамжин ирсэн бичиг үсэг тул тэдний зааж ирсэн арвин туршлагаас суралцсан байна.

1. Өнөөгийн бидний нэрлэж заншсан “Цагаан толгой”, “Монгол хэл” 1-р ангийн сурах

⁷ Монгол хэл шинжлэлийн тайлбар толь бичиг. (2014), 243-р тал

бичгийг, тухайн үед “Үсэглэл” гэж нэрлэдэг байв. Энэхүү сурах бичигтээ элементээр бичсэн бичлэгүүдийг хуудасны доод хэсэгт бичдэг, сурах бичгийнхээ нэлээд хэсэгт үлгэрлэн бичсэн байдаг. Багш нь сайтар тайлбарлаж самбарт бичиж үзүүлдэг, энэ бүхнийг хараад дуурайн бичих гэх мэт аргууд...

2. “Цэвэр бичиг” нэртэй дэвтэр. Хуудаснуудыг ар өвөргүй дуустал бичсэн үлгэр жишээ бичлэгтэй ном шиг хэвлэмэл дэвтрийг тараан өгч, түүнийг нь сурагчид хуулбарлан бичдэг. Б. Цэвэгжав. Цэвэр бичиг (1950), Заах аргын зөвлөмж (1951)
3. Үсгийг анги бүрийн онцлогт тохируулан бичих өөр өөр шугамд бичсэн бичлэгтэй. “Хичээнгүй бичиг” нэртэй дуурайн бичих дэвтэр, заах аргын зөвлөмж (Б. Сэмжид. 1970).
4. “Хичээнгүй бичиг” хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүн энэхүү дэвтэр нь дээрх гурван дэвтрээс бичүүлэх аргачлалаараа нэлээд өөрөөр боловсруулсан юм. Эл дэвтрийг бүтээх болсон шалтгаан нь хүүхдийг долоон наснаас сургуульд хамран сургах (1986) болсонтой холбогдон заах аргын шинэчлэл өөрчлөлт хийх, хэрэглэгдэхүүн бэлтгэн гаргах зэрэг учир холбогдлоос улбаатай. Оросод 7 настай хүүхдийн сургалтад хэрэглэдэг “Пропись” дэвтрийн загвараар хийх талаар МУ-ын гавьяат багш Б.Сэмжидийн саналыг хэлэлцээд аргазүйг Г.Лхаахүү бичиж, аргын дагуу элементээр бичин эх бэлтгэхийг, сурах бичиг хэвлэлийн нэгдсэн редакцын редактор Б.Батсүрэнд үүрэг болгосноор энэхүү дэвтэр бүтсэн түүхтэй. Энэхүү дэвтрийн аргазүйн гол шинэчлэл нь элементийн алдаагүй, зөв бичлэгийг нэг мөр бичиж өгөөд, түүнийг сурагчид сайтар ажиглаад бичлэггүй мөрөнд үсэг үе, үг өгүүлбэрээ дуурайн бичнэ.
5. Г. Лхаахүү. Хичээнгүй бичих заах аргазүй (оюутанд зориулсан зөвлөмж) 1997
6. Ц.Наранцэцэг. Хичээнгүй бичиг 2007, 2013, 2014 (хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүн)
7. Ц.Наранцэцэг нар. Хичээнгүй бичиг 2011 (оюутанд зориулсан хэрэглэгдэхүүн) гэх мэт мэргэжлийн хүмүүс хүүхдийг элементээр сайхан бичүүлж сургахад тодорхой үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэхийн сацуу багш бэлтгэдэг сургуулиуд энэ хичээлийн зүгт

маш нухацтайгаар анхаарлаа хандуулахыг сануулахад илүүдэхгүй болов уу хэмээн бодно.

Дээр дурдсанчлан 7 настай хүүхдийн нас сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохируулан найман настай хүүхдээр бичүүлж байсан, бичих технологи, үйл явцын журмыг нэлээдгүй хөнгөвчлөн өөрчилж, Ардын Боловсролын яам (АБЯ) –ны сайдын 048-р тушаалаар баталгаажсанаар, үсгийн шинэ холболт, зурлага, элементийн бичлэгийг өнөөдрийг хүртэл 30 гаруй жил хэрэглэсээр байна. Тэр үед багш нарын мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ), бага ангийн сургалтыг П.Галсан, Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн (СХУХ), бага ангийн сектор Ч.Жачин нар хариуцаж бид хамтран ажиллаж байлаа. 1987 онд бүх аймгуудын Сургалт заах аргын кабинетийн эрхлэгчид (ЗХУ), одоогийн Орос улсад мэргэжил дээшлүүлж, туршлага судлан энэ бүрэлдэхүүнд миний бие оролцсоны гадна Багшийн сургуульд монгол хэл, уран зохиол, түүний заах аргын багшаар ажиллаж байсан учир дээр дурдсан 4 дэх дэвтэр буюу хэрэглэгдэхүүн, хичээнгүй бичихэд сургах аргазүйг боловсруулах хариуцлагыг хүлээж, өнөөдрийг хүртэл энэ үүргийн дагуу ажилласаар байна.

Хичээнгүй бичигт сургах асуудалд

Хичээнгүй бичгийн (Каллиграфический) хичээлээр үсэг түүний хэрэглүүр, үг өгүүлбэрийг хэрхэн бичих аргазүйг судална. Үсэгзүйн шинжлэх ухаан, сургахзүйн шинжлэх ухааны уялдаа холбоонд нарийн авч үзэх ёстой. Бид шинэ аргазүйг туршин, улам боловсронгуй болгоход хүчин зүтгэж, 18 аймаг, гурван хотын багш нараас санал асуулга явуулж, семинар зөвлөгөө өгөн, хичээнгүй бичигт хэрхэн сургах хийгээд долоон настай хүүхдийг сургах “Хичээнгүй бичиг” (дэвтэр), “Цагаан толгой” номыг зохион, (1987) багш нарыг шинэ аргазүйд сургах үйл явцыг орон даяар хэрэгжүүлсэн юм.

Тухайн шинжлэх ухааны нарийн учир шалтгаан, хөгжлийн түүх, ач холбогдол, хэрэгцээ, хэрэглээг анхааралгүй өнгөц харан, хэдэн үсэг холбон бичих төдий хялбархан үзэж, яавч болохгүй юм билээ. Хүүхдийг бичгийн хэлд сургах ажлын салшгүй нэг хэсэг нь бичих технологийг ойлгуулж, хичээлийг зөв зохион байгуулах явдал юм.

Үсэгзүй нь бичгийн төрөл зүйл, хэлбэр маяг бичих тиг, бичлэгийн явцад баримтлах дэг журам хөгжлийн түүхийг судалдаг хэл

шинжлэлийн салбар ухаан болж, хүний харилцааг тэмдэглэх хэрэглүүр болдог. Энэ утгаараа “сургуулийн өмнө шийдвэрлэвэл зохих олон олон зорилтуудын нэг нь, сурагчдыг хичээнгүй цэвэр сайхан бичүүлж, сургах нэн тэргүүний үйл ажил билээ”⁸ Үсэг бичиг нь дармал болоод гараар бичсэн хоёр өөр хэлбэртэй. Мөн том, бага, загварт ба загварт бус хичээнгүй ба гүйлгэн гэсэн олон хувилбартай байдаг. Тиймээс үсгийн хэрэглээний онцлог, хөгжлийн түүх, сургаж байсан арга барилуудыг судалж, орчин үед яаж зааж сургах аргуудыг, багш бэлтгэж байгаа сургуулийн оюутнуудад танилцуулах, эзэмшүүлэх зорилготой хичээл юм.

Энэ үүднээс хичээнгүй, зөв тигээр бичиж сурах нь ирээдүйн багш нарын мэргэших хичээл мөнөөс мөн. Бичих унших нь өөр өөр орон цагийн дотор байдаг. (Бичгийг хэзээч уншиж болно) Бага сургуулийн үеэс бичгийн хэлд зориудаар суралцаж эхэлдэг. Тиймээс бичгийн хэлтэй болохын салшгүй нэг хэсэг нь хичээнгүй, зөв, сайхан бичих юм. Хичээнгүй бичиж сурах нь хэлний нэг томоохон соёлыг эзэмшиж байна л гэсэн үг. Бичих эв дүй богинохон хугацаанд биелчихгүй гэдэг нь ойлгомжтой. Ер хэнд ч гаргацтай, гүйлгэн бичих чадвар нь 7-8 жилийн уйгагүй хөдөлмөрийн үр дүнд биеллээ олно.

Иймээс үсгийг бичихээс өмнө хүүхдийн гарын хөдөлгөөнийг зохицуулах, гарын хөдөлгөөнийг эвсэлтэй болгох, жижиг булчингуудыг хөгжүүлэх, ажлыг, сэтгэхүйн үйлдлүүдтэй хослон систем дэс дараатай хийлгэж чадвал бичих ажилд тийм ч их бэрхшээл ядаргаа үүсэхгүй. Бид хүүхдээ бичихэд бэлтгэх ажлыг дутуу дулимаг хийж, шууд олон мөр үг үсэг, өгүүлбэр бичүүлэхээр зовоодог нь сургах зүйн алдаа болно гэдгийг анхаарууштай асуудал.

Цэцэрлэг, сургуулийн бэлтгэл үед гар зүгшрүүлэх дасгалууд хийлгэж, бичих арга мэдсэн хүүхдээр, нэг цагт олон үг бичүүлээд байх шаардлагагүй. Гэрт нь ч олон хуудас юм бичүүлж, залхааж бүр ч болохгүй. Үг үсгийг цөөн мөрөөр маш зөв бичихэд л удирдан чиглүүлэх нь зөв зохистой арга болно.

Эл хичээлийг зааснаар суралцагчдыг нягт нямбай, ажигч, гярхай, хичээнгүй цэвэрч, дэг журамтай, бичгийн соёлтой, тэсвэр хатуужилтай, хүн болгон төлөвшүүлээд зогсохгүй гоозүйн ухаарал бий болно. Үсэгзүйн шинжлэх ухааныг улам бүр ухан мэдэх, учир шалтгааны нарийн

ойлголттой болох гэх мэт чухал ач холбогдолтой.

Ер нь сурсны хойно юм болгон амар хялбар санагддаг. Бид сурах явцдаа сургахзүйн хийгээд сэтгэлзүйн тодорхой бэрхшээлүүдийг туулсан нь дамжиггүй. Бид өнөөдөр лекц, семинараа тэмдэглэж, санаа бодлоо илэрхийлэн үлдээхэд үсэг бичиг юутай ч зүйрлэшгүй. Бид эхээс төрөхдөө бичиж сурчаад гарсан юм шиг хүүхдээр ингэж их бичүүлж яадаг юм, “шинжлэх ухаанч” биш юм хийлгэлээ гэж дуугарах хүн мэр сэр байгааг сонсоход харамсмаар ч, тэр хүн тухайн шинжлэх ухааны талаар мэдлэггүй, түүний төлөө сэтгэл зүрхээ зовоогоогүй хүний үг болов уу. Сурч байх үед чинь багш нар нь олон жилийн уйгагүй, үйл ажиллагааны дор оюун бодол, хүч чадвараа дайчилсаар өнөөдрийн хэмжээнд хүргэснийг мартаж болохгүй билээ.

1950-1990 - ээд он хүртэлх үед бичиг үсэг сурсан хүмүүс, маш гоё жигдхэн бичдэг. Гаргац сайтай, харахад тааламжтай. Яагаад гэхээр багш нь хүүхдийн дэвтэр болоод самбарт халуун дулаан харилцаан дунд гоё, сайхан бичиж заадаг байж. Түүнийг шавь нь дуурайн, сайхан бичихийн төлөө мэрийж зүтгэдэг. Багшийн үлгэрлэн, дагуулах чадвар, илүү сайн байсныг илтгэнэ.

Өнөөдөр ЕБС-д сурч байгаа хүүхдийн сайхан бичих талд бага анхаарч байгаад би шүүмжлэлтэй хандаж байна. Сургалтын үйл явцаар хийгдэж байгаа, зааж буй зүйлд “шинжлэх ухааны үндэслэлгүй, таавраар явдаг зүйл” гэж байдаггүй. Академич Ц.Дамдинсүрэн “шинжлэх ухаан гэдэг чинь зарим хүний боддог шиг, хадны мангаа шиг учир нь мэдэгдэхгүй айхавтар юм биш ээ... Амьдралыг зөвөөр тусгасан, хүний санаанд багтаж буй тийм л зүйлийг би шинжлэх ухаан гэж ойлгож байна”⁹ гэж айлдсан байдаг.

Сүүлийн 20 жилд хүүхдийг цэвэр, хичээнгүй бичүүлж сургах талаар, арга зүйн дорвитойхон бүтээл (ном, өгүүлэл) ганц ч гарсангүй. Харин 7 настай хүүхдэд зориулан бидний гаргасан “Хичээнгүй бичиг” дэвтрийг дуурайлган ашиглаж, бизнесийн зориулалттай дэвтэр хийж, сургалтын хэрэглэгдэхүүн нэртэйгээр нийтэд зарж, ашгийн хойноос хөөцөлдөж байгаа багш нар нэгийг бодож үзүүштэй. Харин, МУБИС-ийн Багшийн сургуулийн Монгол хэл, нийгмийн ухааны тэнхим зохиогчийн эрхийг ноцтой зөрчин, алдаа мадаг ихтэй гарч байгаа дэвтрүүдийг судлан үзэж, хэлэлцүүлэг зохион байгуулж, (2015) энэ

8 Г.Лхаахүү. (2015), *Хичээнгүй бичиг заах аргазүйн зөвлөмж. 6 дахь тал*

9 *Хэлбичгийн зарим асуудал. 1959, 6 дахь тал*

талаар олон улсын бага хуралд хэдэн хүнээр илтгэл хэлэлцүүлсэн нь (2016) дэмжүүштэй, сайшаалтай үйл явдал болсон билээ.

Энэ ялдамд, багш бэлтгэх сургуулиудад заах хичээнгүй бичиг хичээлийн хөтөлбөртэй уялдуулан бичсэн Г.Лхаахүү “Хичээнгүй бичиг заах аргазүйн зөвлөмж” (2015) номыг сургалт, судалгаандаа судлан ашиглавал, үсэгзүй, сургалтын бичлэгээр шинжлэх ухааны үндэстэй аргазүй болох юм шүү хэмээн хэрэглэгчдэд зөвлөж байна. Ингэснээр, дараах үр дүнд хүрч болно хэмээн бид үзэж байгаа юм. Тухайлбал,

- ü Бичих эв дүйд зөв суралцан, хүүхэд заавал сурч, эзэмшсэн байх мэдлэг чадварын нэг гэдгийг мэдүүлэх;
- ü Багш бэлтгэж байгаа сургуулийн оюутнууд үсэг бичгийн үүсэл, сургаж байсан аргын талаар асууж сураглах нь нэлээд байна. Түүнд хариулт болох болов уу;
- ü Үсэгзүйн шинжлэх ухаан хийгээд хичээнгүй бичүүлж сургахын ач холбогдол, бичгийн соёлд суралцахыг ойлгуулах болно.

Ер нь, үсэгзүй, кирил үсгийн хичээнгүй бичгийн сургалттай уялдуулж дараах хэдэн зүйл дүгнэлтийг хаана хаанаа бодож үзүүштэй байгаа юм. Үүнд:

- Үсэгзүйн шинжлэх ухааныг нарийвчлан ойлгож, багш бэлтгэдэг сургуулиуд, ялангуяа бага боловсролын багш нарт мэргэших хичээлийн түвшинд зааж эзэмшүүлэх сургалтыг эрчимжүүлэх;
- Хичээнгүй бичигт сургахзүйн технологи, зорилго зорилтыг багш, оюутнууд сайтар ойлгон, дадал, чадвар эзэмших нарийн холбоонд нь авч үзэж, зааж сургах;
- Өнөөгийн нөхцөлд хүмүүсийн гараар бичих чадвар муудаж, бичмэлээр бичсэн бичгийг уншиж чадахгүй болсонд сургалтын байгууллагууд дүгнэлт хийх цаг болсон байна. Жишээ нь эмийн жор бичиж байгаа эмч нарын бичгийг энгийн хүн байтугай эмзүйч нь ч уншиж чадахгүй байна. Энэ бол сургалтад гарсан алдаа гэж үзэн дүгнэлт хийх;
- Хүүхдэд зориулан гаргаж байгаа хэрэглэгдэхүүн, элдэв тараах материалуудад мэргэжлийн үүднээс зөвлөгөө, зөвшөөрөл өгч, хяналт тавих;
- 6,7 настай хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт зохицуулан өөрчилсөн, үсгийн

бичлэг, элементийн өөрчлөлтүүд, үсэг үг бичихийн өмнөх бэлтгэлийг анхаарахгүй, өөрийнхөө сурсан, дадсан аргаар бичүүлж байгаагаас, бичих ажил, хүүхдэд хүнд мэт сэтгэл төрүүлж байгааг багш нар анхаарах нь зүйтэй болов уу.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Базаррагчаа, М., Лхаахүү, Г. (2008). *Монгол хэл I анги. Багийн ном*. Улаанбаатар Экимто ХХК
- Буянтогтох, Г., ба бусад. (2014). *Монгол хэл шинжлэлийн тайлбар тольбичиг*. МУИС пресс хэвлэлийн газар
- Дамдинсүрэн, Ц. (1959). Монгол хэл бичгийн зарим асуудал.
- Лувсанбалдан, Х., Шагдарсүрэн, Ц. (1971). Монголчуудын үсэг бичиг үг хэллэгийн түүх. Улаанбаатар
- Лхаахүү, Г. (1997), (2015). Хичээнгүй бичиг заах арга зүйн зөвлөмж. Улаанбаатар: Битпресс
- Надмид, Ж. (1975). *Сурган хүмүүжүүлэх” сэтгүүл №4 80, 81 дэх тал. Үсэгзүй. Сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакц, Улаанбаатар*